

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР АВАХАД БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ:

- 1. Холбогдох хууль эрх зүйн актуудыг уншиж судлах. Үүнд:**
 - Зөвшөөрлийн тухай хууль
 - Эрүүл мэндийн тухайн хууль 19 дүгээр зүйл
 - Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль 2 дугаар бүлэг
 - Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль 14 дүгээр зүйл
 - Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль 27 дугаар зүйл
- 2. Стандарт хэмжил зүйн газраас холбогдох стандартыг авч судлах. Жиш:**
 - Клиникийн бүтэц, үйл ажиллагаа MNS6673:2017
 - Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS5260:2015

Тухайн өөрийн эрхлэх гэж буй чиглэлийн үйл ажиллагааг холбогдох стандартын дагуу хүний нөөц, орон байр, тоног төхөөрөмжид заасан шаардлагын дагуу бүрдүүлэх, засаж тохижуулах.

- 3. Холбогдох Эрүүл мэндийн сайдын хэрэгжиж буй тушаал, журам эрх зүйн актуудыг судлах. Жиш: ЭМС-ын 2019 оны А/537, 2009 оны А/388, 2024 оны А/230 бусад.**
4. Зөвшөөрөл хүсэгч нь Зөвшөөрлийн тухай хуулийн 4.1-т заасан нийтлэг шаардлагыг хангасан байна.
5. Зөвшөөрөл хүсэгч хүсэлт өгөхдөө Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийг үндэслэн хүсэлт гаргана. Үүнд:
 - 1.Зөвшөөрөл хүсэгч зөвшөөрөл хүссэн өргөдлийг түүнд хавсаргах баримт бичгийн хамт эрх бүхий этгээдэд гаргана.
 - 2.Зөвшөөрөл хүссэн өргөдөл нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан нийтлэг шаардлагыг хангасан байна. /Албан хүсэлт: Хаяг байршил болон дотор өрөөний зохион байгуулалт, өрөөний хэмжээг тусгасан байх/
 - 3.Зөвшөөрөл хүсэгч өргөдөлд зөвшөөрлийн ангилал, түүнд холбогдох үйл ажиллагааны болон байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглах зорилго, үндэслэлийг тодорхой тусгах бөгөөд дараах баримт бичгийг өргөдөлд хавсаргана:
 - 3.1.зөвшөөрөлд тавигдах хуульд заасан нийтлэг нөхцөл, шаардлага хангасныг нотолсон баримт бичиг;
 - 3.3.хуульд тусгайлан заасан нөхцөл, шаардлага хангасныг нотолсон баримт бичиг.
6. Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5.Тусгай зөвшөөрөл хүсэгч байгууллага нь энэ хуулийн 19.4-т заасан тэргүүлэх чиглэлийн хүрээнд дараахь тохиолдолд тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагаас хэрэгцээний тодорхойлолт авна:
7. Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5.4.эрүүл мэндийн байгууллагын зориулалтын барилга байгууламж барих, өргөтгөх, зориулалтаар өөрчлөн засварлах.

8. Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.6.Тусгай зөвшөөрөл хүсэгч байгууллага нь хэрэгцээний үнэлгээ хийлгэх тухай хүсэлтээ мэргэжлийн үйл ажиллагааны төслийн хамт тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагад хүргүүлэх бөгөөд төсөлд тухайн байгууллагын болон тусламж, үйлчилгээний төрөл, төлөвлөсөн байршил, барилга байгууламжийн талбайн төлөвлөлт, хүний нөөцийн бүрэлдэхүүн, техник, технологийн хүчин чадал, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг тусгасан байна.
9. Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.7.Хэрэгцээний үнэлгээг тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагаас сонгон шалгаруулсан мэргэжлийн нийгэмлэг, холбоо гүйцэтгэнэ.
10. Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.9.Тусгай зөвшөөрөл хүсэгч байгууллага хэрэгцээний тодорхойлолтыг үндэслэн барилгын зураг төсвийг боловсруулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагаар хянуулж батлуулна.
11. Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.10.Тусгай зөвшөөрөл авахад Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3-т зааснаас гадна дараах баримт бичгийг бүрдүүлнэ:
 - 19.10.1.үүсгэн байгуулагчийн шийдвэр;
 - 19.10.2.тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагаас олгосон хэрэгцээний тодорхойлолт;
 - 19.10.3.энэ хуулийн 19.6-д заасан мэргэжлийн үйл ажиллагааны төсөл;
 - 19.10.4.эрүүл мэндийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагын барилга нь мэргэжлийн үйл ажиллагааны төсөл болон батлагдсан зураг төсвийн дагуу баригдсан, зориулалтын дагуу ашиглаж болох эсэх талаар холбогдох байгууллагаас гаргасан шийдвэр;
 - 19.10.6.эмнэлгийн мэргэжилтний бүрэлдэхүүний жагсаалт, мэргэжилтний бүртгэлийн дугаар, хөдөлмөрийн харилцаа үүсгэхийг зөвшөөрсөн зөвшөөрөл.
12. Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.10 дахь заалтад заасан шаардлагуудыг Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/100 дугаар тушаалын 3 дугаар зүйлээс дэлгэрэнгүй харах. /ЭМТХ 19 дүгээр зүйлийн “19.11.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага энэ хуулийн 19.10-т заасан хүсэлт гаргагчийн баримт бичгийг хүлээн авч, өргөдлийг хянан үзэх орон тооны бус шинжээчийн баг томилон ажиллуулах бөгөөд баримт бичигт тавигдах шаардлагыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасан тул ЭМС-ын А/100 дугаар тушаалаас дэлгэрүүлэх/

Нэмэлтээр бүрдүүлэх баримт бичиг жагсаалт:

13. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар. Үүнд: / Гэрчилгээнд тухайн эрүүл мэндийн чиглэлээр эрхлэх гэж буй үйл ажиллагааны чиглэлийг нэмүүлсэн байх/
14. Үүсгэн байгуулагчийн мэдээлэл ЭМС-ын 2023 оны 100 дугаар тушаалын батлагдсан хүснэгтийн дагуу;
15. Эрүүл мэндийн ажилтны мэдээлэл ЭМС-ын 2023 оны 100 дугаар тушаалын батлагдсан хүснэгтийн дагуу;

16. Тоног төхөөрөмжийн жагсаалт ЭМС-ын 2023 оны 100 дугаар тушаалын батлагдсан хүснэгтийн дагуу;
17. ЭМБ-ын байрны гадаад болон дотоод схем зураг/байршил болон дотор өрөөний зохион байгуулалт, өрөөний хэмжээг тусгасан байх/
18. Эрүүл мэндийн байгууллагын танилцуулга;
19. Компаний дүрмийн хуулбар;
20. Эрүүл мэндийн байгууллагынажиллах дүрэм;
21. Ажилтан, ажилчдын анкет /ТАХ-ын 1-р маягтаар/;
22. Компанийн захирлын ажилчдыг томилох тухай тушаал;
23. Эм зүйч, эм найруулагч, эмч, сувилагч нарын дипломын хуулбар, нотариатаар баталгаажуулах;
24. Эм барих, эмчлэх эрхийн лицензийн хуулбар, нотариатаар баталгаажуулах;
25. Хөдөлмөрийн гэрээ;
26. Албан тушаалын тодорхойлолт;
27. Иргэний үнэмлэхний хуулбар;
28. Эм ханган нийлүүлэх байгууллагатай /3-аас дээш/ хийсэн гэрээ /эмийн сан бол/;
29. Эрүүл мэндийн байгууллагын дүрэм /Эрүүл мэндийн тухай хуулийн 21.3-т зааснаас гадна байгууллагын нэр, албан ёсны хаяг, үйл ажиллагааны төрлийг тусгана /, ажиллах дотоод журам;
30. Түрээсийн гэрээ, өөрийн байртай бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар;
31. Ариутгал, халдваргүйтгэлийн газартай хийсэн гэрээний хуулбар хувь;
32. Хог хаягдлын гэрээ;
33. Аж ахуйн нэгжин захирал нь эмч, эмнэлгийн ажилчидтай хийсэн хөдөлмөрийн гэрээ
34. Эмч, эмнэлгийн ажилчдыг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах.